

Төлөвлөгөө хянасан:

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**


  
..... Б. ДЭЛГЭРСАЙХАН  
(гарын үсэг)

(2026-01-29)




Төлөвлөгөө баталсан:

**АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА**

  
..... Ж.ЦОЛМОН  
(гарын үсэг)

(2026-01-29)



### АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№ д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв, эх үүсвэр /сая төгрөг /	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах нэгж	
	<b>Зорилт 1.Осол зөрчлийн мэдээллийг ангиалан бүртгэнэ.</b>		<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Осол, мэдээллийн үүсгэсэн.</b>	<b>зөрчлийн санг</b>	<b>Осол, зөрчлийн мэдээллийг ангиалан бүртгэнэ</b>	<b>I-IV улирал</b>	<b>ЗСТ</b>

1	1.1	Аюулгүй ажиллагааг сайжруулах зорилго бүхий осол, зөрчлийн мэдээллийн санг хөтлөнө.	-	Бүртгэлийн ажлын явц	Нийт 42 зөрчлийн тохиолдлыг ангилан бүртгэж, сан үүсгэсэн.	<b>Тухай бүр:</b> Мэдээллийг бүрэн авч, ангилан бүртгэж, санг хөтөлнө.	I-IV улирал	ЗСТ
2	1.2	Нислэгийн зөрчил, тохиолдлыг ангилан бүртгэх цахим хуудас, сайн дурын мэдээлэл авах, мэдээлэх үйл ажиллагааг шинэчлэн сайжруулна.	-	Ажлын явц Шинэчилсэн эсэх	Бүртгэлийн ECCAIRS v6.1 программ, цахим хуудас, утас, факс, мэйлээр мэдээлэл авч байна.	<b>I улирал:</b> Осол, зөрчлийг бүртгэх, мэдээлэх ажиллагааг бүрэн гүйцэт хийх, үйл ажиллагааг сайжруулж, онлайн цахим хувилбарыг ашиглана. <b>II улирал:</b> Мэдээллийг цахимжуулах үйл ажиллагааг сайжруулж, ECCAIRS/ADREF программын цахим шинэчилсэн хувилбарыг ашиглана. <b>III-IV улирал:</b> Цахим хуудсаар мэдээлэл дамжуулах үйл ажиллагаа, ангилан бүртгэх ажиллагааг сайжруулж, албаны цахим хуудсан дахь мэдээлэл авах, дамжуулах системийг шинэчилсэн байна.	I-IV улирал	ЗСТ
<b>Зорилт 2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, шалтгаан нөхцөлийг тогтооно.</b>				<b>Шинжлэн шалгах ажиллагааны явц</b>	<b>Эцсийн урьдчилсан гаргах тайлан, тайлан</b>	<b>Шинжлэн шалгах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулсан байна.</b>	I-IV улирал	<b>ШШТ</b>
3	2.1	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил гарсан тохиолдолд шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан, дүгнэлт гаргана.	-	ШША явуулж, тайлан, дүгнэлт гаргасан эсэх	ШША 6 хийгдэж, 3 эцсийн тайлан, 2 урьдчилсан тайлан гаргасан.	<b>Тухай бүр:</b> Осол, ноцтой зөрчлийн үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан гаргана. Зөрчлийн үндсэн шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлсон урьдчилсан тайлангийн төслийг холбогдох газруудад хүргүүлж, санал авна. Эцсийн тайланг холбогдох байгууллагуудад болон шаардлагатай тохиолдолд Олон улсын иргэний нисэхийн байгууллагуудад /ОУИНБ/-д англи хэл дээр хөрвүүлэн хүргүүлнэ.	I-IV улирал	ШШТ

4	2.2	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлөөс бусад зөрчил, тохиолдлын үед болон шаардлагатай тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаа явуулж, тайлан, дүгнэлт гаргана.	-	ШША явуулж, тайлан, дүгнэлт гаргасан эсэх	ШША хийж, тайлан, дүгнэлт гаргасан.	<b>Тухай бүр:</b> Осол, ноцтой зөрчлөөс бусад зөрчил, тохиолдлын үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан дүгнэлт гаргана.	I-IV улирал	ШШТ
<b>Зорилт 3. Осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой аюулгүй байдлын зөвлөмж гаргана.</b>				<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Аюулгүй ажиллагааны арван гаргасан.</b>	<b>Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулсан байна.</b>	I-IV улирал	ШШТ
5	3.1	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны тайланг үндэслэн нислэгийн аюулгүй байдлын зөвлөмж /АБЗ/ гаргана.	-	Аюулгүй байдлын зөвлөмж гаргасан эсэх	7 зөвлөмж гаргаж хүргүүлсэн.	<b>Тухай бүр:</b> Нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор шинжлэн шалгасан тайлан, дүгнэлтийг үндэслэн осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын зөвлөмжүүдийг гаргана.	I-IV улирал	ШШТ
6	3.2	Аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэн хяналт тавьж, үнэлэн тайлагнана.	-	Тайлангийн тоо	Зөвлөмжийн биелэлтийг улирал бүр тайлагнасан.	<b>Тухай бүр:</b> Аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэн авч, хэрэгжилтэд хяналт тавьж, ЗТЯ-нд улирал бүр /4 удаа/ танилцуулна.	I-IV улирал	ШШТ
<b>Зорилт 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.</b>				<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Үйл ажиллагааны явц</b>	<b>Шинжээчдийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг авч, туршлага солилцон, гадаад хамтын ажиллагааг сайжруулсан байна.</b>	I-IV улирал	ЗСТ, ШШТ
7	4.1	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтоосон хугацаанд байршуулна..	-	Байршуулсан мэдээллийн тоо	Холбогдох мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулан мэдээлдэг.  24 цагийн мэдээлэл дамжуулах утас, жижүүр шинжээчид ажиллуулж байна.	<b>Тухай бүр:</b> ОУИНБ болон гадаад улс орны агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зорилго, ач холбогдлыг олон нийтэд тухай бүр танилцуулж сурталчилна.  Мэдээллийг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт улирал бүрт 4-5 мэдээ байршуулна.	I-IV улирал	ЗСТ

8	4.2	Албаны гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааны асуудлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2 арга хэмжээ зохион байгуулсан. ICAO болон ОУ-ын нисэхийн аюулгүй байдлын шинжлэн шалгах нийгэмлэг /ISASI/-ээс зохион байгуулагдаж байгаа сургалт-семинарт 1 хүн, ICAO болон USOAPCMA-ын аудит шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй сургалтад 2 хүн хамрагдсан/	<b>Тухай бүр:</b> Шинжлэн шалгах ажиллагаанд тухай бүр хамтарч ажиллана, шинжээчдийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг авч, туршлага солилцон, гадаад хамтын ажиллагааг сайжруулсан байна. 1-2 үйл ажиллагаа зохион байгуулна.	I-IV улирал	ШШТ
9	4.3	ИКАО-оос Монгол улсад Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын олон улсын аудит хөтөлбөр, байнгын хяналт аргачилалын хүрээнд хийгдэх аудит шалгалтад хамрагдах, шалгалт болохтой холбогдуулан бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэнэ.	-	Аудит шалгалт өгсөн байдал, үнэлгээ	ИКАО-ийн аудит шалгалт 2025 оны 09 сард урьдчилсан шалгалт хийгдэж, өгөгдсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажилласан.	<b>I улирал:</b> Бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэнэ. <b>II улирал:</b> Төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Аудит шалгалтад хуваарийн дагуу хамрагдана.	I-II улирал	ШШТ
<b>Зорилт 5. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулна.</b>			<b>Хэрэгжилтийн явц</b>		<b>Төсөв баталсан, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн нөөц бүрдүүлсэн.</b>	<b>Төсвийн алдагдалгүй, зөрчил дутагдалгүй хэрэгжүүлсэн байна.</b>	I-IV улирал	<b>ЗСТ</b>
10	5.1	Албаны 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг батлуулах, хөрөнгө, санхүүгийн бүртгэл хөтөлж, хагас болон бүтэн жилийн хэрэгжилтийн тайлан гаргана.	-	Төсвийг батлуулсан, тайлагнасан эсэх	Албаны төсөв, хөрөнгийн бүртгэлийг хөтөлж тайлагнасан. Хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг гаргасан.	<b>I улирал:</b> Албаны 2026 оны зардлын төсвийг холбогдох хууль, журмын дагуу гаргаж батлуулсан байна. <b>II улирал:</b> Хөрөнгө санхүүгийн хагас жилийн бүртгэл хөтөлж, тайлан гаргасан байна. <b>III-IV улирал:</b> Зардлын гүйцэтгэлийг гаргаж /e-balance/ тайлагнана. төсвийн алдагдалгүй,	I-IV улирал	<b>ЗСТ</b>

					зөрчил дутагдалгүй хэрэгжүүлсэн байна.			
1 1	5.2	Шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай багаж тоног, төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл зэргийн нөөцийг бүрдүүлж, байнгын бэлэн байдалд байлгана.	-	Батлуулсан төсвийн тоо, бүрдүүлсэн нөөцийн тоо, бэлэн байдалд байгаа эсэх	4 шинжлэн шалгагчид хөдөлмөр хамгааллын өвлийн хувцас, 9 хүнд зуны хувцас хэрэглэл, компьютер, ухаалаг самбар, архивын сейф зэргээр хангасан.	<b>I-II улирал:</b> Иж бүрдэл, хэрэгсэл, төхөөрөмжийн судалгааг гаргаж нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай төсөв, тооцоог гаргаж батлуулсан байна. <b>III-IV улирал:</b> Нормын дагуу бэлтгэж, бэлэн байдлыг хангасан байна. Нэмэлт шаардлагатай төсвийг дараа оны төсөвт тусгана.	I-IV улирал	ЗСТ
1 2	5.3	Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг хадгалах, дэмжих, урамшуулах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын төлөвлөгөө батлуулсан эсэх, хэрэгжилтийн хувь	2025 онд албан хаагчдыг мэргэшүүлэх, урамшуулах, дэмжих үйл ажиллагаанд 3 ажилтан хамрагдсан.	<b>I улирал:</b> Хүний нөөцийн бодлого боловсруулах ажиллагааг эхлүүлж, сургалтын төлөвлөгөө гаргаж батлуулна. <b>II улирал:</b> Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. <b>III-IV улирал:</b> Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангаж, зохион байгуулсан ажлыг тайлагнасан байна.	I-IV улирал	ЗСТ
<b>Зорилт 6. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангана.</b>			<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлтийг ЗТЯ-нд хүргүүлсэн.</b>	<b>Холбогдох тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан байна.</b>	<b>I-IV улирал</b>	<b>ЗСТ</b>	
13	6.1	Иргэний нисэхийн осол, зөрчлийн мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийнэ.	-	Дүн шинжилгээ хийсэн, ажлын явцыг тайлагнасан эсэх	2010-2024 онд гарсан осол, зөрчлийн мэдээлэлд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлтийг ЗТЯ-нд 2025.04.29 27/25 тоотой хүргүүлсэн.	<b>I улирал:</b> Судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлнэ. <b>II улирал:</b> Осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийнэ. <b>III-IV улирал:</b> Мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, тайлбар гарган тайлагнасан байна.	I-IV улирал	ЗСТ

14	6.2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал, сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг ханган тайлагнана.	-	Тайлагнасан ажлын тоо	Өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ЗТЯ-ны ТЗУГ, ХШҮДАГ-т тайлагнасан.	<b>Тухай бүр:</b> Биелэлтийг бүрэн гүйцэт гарган хугацаанд нь улирал бүр тайлагнана. /4 удаа/	I-IV улирал	ЗСТ
<b>Зорилт 7. Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацаа (2020-2024)-ны дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангана.</b>				<b>Цахимжуулах ажлын явц</b>	<b>2025 оны байдлаар</b>	<b>Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулсан байна.</b>	<b>I-IV улирал</b>	<b>ЗСТ</b>
15	7.1	Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, албан хэрэг хөтлөлтөд ашиглана.	-	Тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлсэн эсэх	2 албан хаагчийн тоон гарын үсгийн хэрэглээг нэмж нэвтрүүлсэн.	<b>I-II улирал:</b> Ажилтнуудын тоон гарын үсгийн хэрэглээг албан бичиг хэрэг хөтлөлтөд нэвтрүүлж ашиглана. <b>III-IV улирал:</b> Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, албан хэрэг хөтлөлтөд бүрэн ашигласан байна.	I-IV улирал	ЗСТ
16	7.2	Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэт техник технологи нэвтрүүлнэ.	-	Шинэ техник технологи нэвтрүүлсэн тоо	2025 оны 12 сард шинэ технологи нэвтрүүлэх 1 ажиллагаа хийгдсэн.	<b>I-II улирал:</b> Шинэ технологи нэвтрүүлэх ажиллагааг эхлүүлж, шинээр худалдаж авсан 1 программ хангамжийн туршилт, сургалт-судалгааны ажлыг хийж, Монгол улсад ашиглагдаж буй агаарын хөлгүүдийн төрөл, маягийн судалгаанд тулгуурлан программын тохиргоо /агаарын хөлгийн тоноглол, эд ангийн техник үзүүлэлтүүд, газар зүйн зураглал, холбоо навигаци, нисэх буудлуудын өгөгдөл г.м/ нэмэлт тохируулгыг хийж ашиглана. <b>III-IV улирал:</b> Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд агаарын хөлгийн нислэгийн өгөгдлийг тайлж унших ажиллагаанд шинэ программ хангамжийг бүрэн ашигласан байна.	I-IV улирал	ЗСТ

17	7.3	Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын журам боловсруулж батлуулах, журмын хэрэгжилтийг хангана.	-	Журам боловсруулсан эсэх, төлөвлөгөөний хэрэгжилт	Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын журам боловсруулж эхэлсэн.	<b>I-II улирал:</b> Байгууллагын эрсдэлийг тодорхойлж Зам, тээврийн яаманд хүргүүлнэ. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж “Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын журам” боловсруулж, батлуулна. <b>III-IV улирал:</b> Журмын дагуу эрсдэлээ тодорхойлж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана.	I-IV улирал	ЗСТ
----	-----	---	---	---	--	--	-------------	-----

—oOo—

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:  
 Захиргаа, судалгааны тасаг  
 Техникийн шинжлэн шалгагч П.Гэрэлчимэг  
 Холбоо барих утас: 7128-5099  
 Цахим шуудан: gerelchimeg@aaib.gov.mn